



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/430

Арвайхээр


┌ Буцалтгүй тусламж үзүүлэх тухай ─┐

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Орон нутагт эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төслийн хүрээнд ажиллах эмч нарын нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 1,000,000 (нэг сая) төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.

2.Дээрх 1,000,000 (нэг сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100957